



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2023 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 10

Хажуу шинэ-Ус

Хоршоог хөгжүүлэх сангийн 2023 оны  
салбар чиглэл батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар батлагдсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсгийн 3.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит аравдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:


1. Говь-Угтаал сумын хоршоог хөгжүүлэх сангийн 2023 оны салбар чиглэлийг хавсралтаар баталсугай.

2. Зээл олгоходо батлагдсан салбар чиглэлийг баримтлан, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг төсөл сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий хороонд үүрэг болгосугай.


3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Булган)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ПУРЭВСЭНГЭ



Говь-Угтаал сумын иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын 2023 оны 06 дугаар сарын 29-ний  
өдрийн 10. тогтоолын нэгдүгээр хавсралт



ГОВЬ-УГТААЛ СУМЫН ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН  
2023 ОНЫ ЧИГЛЭЛ

Д/д	Салбар чиглэл
1	Орон нутгийн онцлогийг харуулсан бэлэг дурсгал, гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэл/ Сур,суран эдлэл/
2	Хүнсний ногоо тариалах
3	Малын тэжээлийн ургамал тариалах
4	Хоёрдогч түүхий эд боловсруулах, хог хаягдал ангилан ялгах
5	ХАА-н түүхий эд боловсруулах, хог хаягдал ангилан ялгах
6	Модон эдлэл
7	Өндөр ашиг шимтэй (мах, сүүний ) малыг өсгөн үржүүлэх /сүргийг бий болгох
8	Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх